



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2021/175/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:              Б.Цэрэнчимэд Утас: 99890393      Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт .....	17
Залруулсан алдаа .....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
Аудитын зөвлөмж .....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, 7  
ХӨДӨӨ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  
Ж.БАТТӨР ТАНАА

2021.02.05 № 2/16

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод

• 005021040

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>308,060,999.89</u></b>	<b><u>117,020,029.78</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	15,779,000.00	4,280,044.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,453,044.52
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	15,779,000.00	2,827,000.00
3351	Байгууллагаас авах авлага	15,779,000.00	2,827,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	292,281,999.89	112,739,985.26
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	219,799,600.28	41,347,612.96
35110	Тусгай зориулалттай материал	219,538,900.28	41,347,612.96
35130	Эм боох материал	260,700.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	61,356,399.61	60,721,372.30
35410	Бичиг хэргийн материал	5,385,006.31	3,091,096.00
35420	Аж ахуйн материал	38,062,472.00	41,832,275.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,043,700.00	1,861,400.00
35440	Түлш, шатах тослох материал	16,210.30	87,590.30
35450	Барилгын засварын материал	304,425.00	304,425.00
35470	Бусад хангамжийн материал	13,544,586.00	13,544,586.00
35600	Мал амьтад	11,126,000.00	10,671,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>543,715,021.82</u></b>	<b><u>616,714,938.25</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	543,715,021.82	616,714,938.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	367,140,021.82	440,389,938.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	340,732,740.00	340,732,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,641,305.28)	(30,293,810.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,240,200.00	173,550,727.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(111,582,576.22)	(128,687,403.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,980,243.01	110,171,154.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,593,751.23)	(37,910,941.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,496,070.85	22,496,070.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,551,599.19)	(13,434,786.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,040,000.00	6,276,188.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,980,000.12)	(2,510,000.16)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	176,575,000.00	176,325,000.00
39301	Програм хангамж	6,680,000.00	7,780,000.00

**Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,030,000.00)	(3,380,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	171,925,000.00	171,925,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>851,776,021.71</b>	<b>733,734,968.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,148,989.33</b>	<b>78,393.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,148,989.33	78,393.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,148,989.33	78,393.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	90,661.90	20,493.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	987,522.00	(0.00)
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	70,805.43	57,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	70,805.43	57,900.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>850,627,032.38</b>	<b>733,656,575.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	850,627,032.38	733,656,575.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,909,074.85	448,909,074.85
51101	Өмч: - төрийн	448,909,074.85	448,909,074.85
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	317,231,159.63	200,260,702.28
51210	Өмнөх үеийн үр дүн	923,954,346.39	317,231,159.63
51220	Тайлант үеийн үр дүн	(606,723,186.76)	(116,970,457.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,486,797.90	84,486,797.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>851,776,021.71</b>	<b>733,734,968.03</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>444,746,891.77</b>	<b>896528221.07</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,653,363.77</b>	<b>457241931.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,653,363.77	457241931.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,653,363.77	457241931.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,032,200.00	1500000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,621,163.77	455741931.98
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>435,093,528.00</b>	<b>439286289.09</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	324,271,700.00	432337600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	324,271,700.00	432337600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	110,821,828.00	6948689.09
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6200000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,621,828.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00	748689.09
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>475,967,845.11</b>	<b>562907862.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>475,967,845.11</b>	<b>562907862.11</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>445,283,165.02</b>	<b>562737369.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>192,198,617.26</b>	<b>180153700.00</b>
210101	Үндсэн цалин	192,198,617.26	135099525.00
210102	Нэмэгдэл	-	39890875.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5163300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,918,658.22</b>	<b>24320800.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,412,671.31	17114600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,923,747.86	1801600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,539,000.89	1441300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	367,567.74	360300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,675,670.42	3603000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,183,622.00</b>	<b>16826278.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,367,507.00	2136100.00
210302	Түлш, халаалт	21,882,306.70	12186454.00
210303	Цэвэр, бохир ус	1,933,808.30	2503724.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,486,975.00</b>	<b>51902792.98</b>
210401	Бичиг хэрэг	3,378,500.00	6442894.00
210402	Тээвэр, шатахуун	15,030,180.00	13246670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,614,330.00	1713800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	42300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,348,215.00	28057128.98
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	115,750.00	
210408	Бараа материал акталсны зардал	-	2400000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>705500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	260700.00
210502	Хоол, хүнс	-	283100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	161700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,758,600.00</b>	<b>0.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	235,100.00	
210604	Урсгал засвар	4,523,500.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,153,800.00</b>	<b>3733000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,153,800.00	3733000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>107,420,571.00</b>	<b>168667077.24</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,531,351.00	166724877.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	385,120.00	750000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,100.00	309000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400000.00
210807	Газрын төлбөр	66,000.00	406200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,162,321.54</b>	<b>116428220.89</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	74590510.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	60,162,321.54	41837710.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,684,680.09</b>	<b>170493.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,029,400.00</b>	<b>150000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	800,000.00	

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,419,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,810,400.00	150000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>655,280.09</b>	<b>20493.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	655,280.09	
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		20493.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(31,220,953.34)</b>	<b>333620358.96</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>575,502,233.42</b>	<b>450590816.31</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	575,502,233.42	450590816.31
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(575,502,233.42)</b>	<b>-450590816.31</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(606,723,186.76)</b>	<b>-116970457.35</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>437,125,728.00</b>	<b>440786289.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,032,200.00</b>	<b>1500000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,032,200.00</b>	<b>1500000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,032,200.00	1500000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,032,200.00	1500000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>435,093,528.00</b>	<b>439286289.09</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>324,271,700.00</b>	<b>432337600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	324,271,700.00	432337600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>110,821,828.00</b>	<b>6948689.09</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		620 0000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,621,828.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00	748689.09
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>425,669,628.00</b>	<b>433286289.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>425,669,628.00</b>	<b>433286289.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>394,945,347.91</b>	<b>430947796.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>160,213,100.00</b>	<b>180153700.00</b>
210101	Үндсэн цалин	124,736,900.00	135099525.00
210102	Нэмэгдэл	30,399,200.00	39890875.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,077,000.00	5163300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,032,300.00</b>	<b>24320800.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,621,900.00	17114600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,602,600.00	1801600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,282,100.00	1441300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	320,500.00	360300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,205,200.00	3603000.00

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,004,100.00	17813800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,175,507.00	2136100.00
210302	Түлш, халаалт	20,894,784.70	13173976.00
210303	Цэвэр, бохир ус	1,933,808.30	2503724.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,580,500.00	19294400.00
210401	Бичиг хэрэг	3,445,000.00	2627800.00
210402	Тээвэр, шатахуун	10,307,500.00	9768900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,710,000.00	2206300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	42300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,118,000.00	4649100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	892,700.00	7161700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	892,700.00	7161700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,517,900.00	2854200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	489,900.00	130700.00
210604	Урсгал засвар	11,028,000.00	2723500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,245,800.00	3733000.00
210702	Дотоод албан томилолт	7,245,800.00	3733000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	151,958,947.91	175616196.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	151,069,727.91	173673996.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	385,120.00	750000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,100.00	309000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400000.00
210807	Газрын төлбөр	66,000.00	406200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,500,000.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,724,280.09</b>	<b>2338493.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,069,000.00	2318000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,419,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,650,000.00	2318000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	655,280.09	20493.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	655,280.09	
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	20493.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,456,100.00</b>	<b>7500000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,456,100.00</b>	<b>7500000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,456,100.00</b>	<b>7500000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	11,456,100.00	7500000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,456,100.00	7500000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,456,100.00)</b>	<b>-7500000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	0.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	0.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,909,074.85	169,455,247.97	838,985,896.32	1,457,350,219.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	84,968,450.07	84,968,450.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,909,074.85	169,455,247.97	923,954,346.39	1,542,318,669.21
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(84,968,450.07)	-	(84,968,450.07)
Тайлант үеийн үр дүн	-	-	(606,723,186.76)	(606,723,186.76)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	317,231,159.63	850,627,032.38
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	317,231,159.63	850,627,032.38
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	317,231,159.63	850,627,032.38
Тайлант үеийн үр дүн	-	-	(116,970,457.35)	(116,970,457.35)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.28	733,656,575.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	433,837,600.00	433,817,107.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	433,837,600.00	433,817,107.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	431,519,600.00	431,499,107.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	180,153,700.00	180,153,700.00
210101	Үндсэн цалин	135,069,200.00	135,099,525.00
210102	Нэмэгдэл	40,007,500.00	39,890,875.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,077,000.00	5,163,300.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,320,800.00	24,320,800.00
210201	Тэтгэврийн даатгал	17,114,600.00	17,114,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,801,600.00	1,801,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,300.00	1,441,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	360,300.00	360,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,603,000.00	3,603,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,813,800.00	17,813,800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,136,100.00	2,136,100.00
210302	Түлш, халаалт	13,174,500.00	13,173,976.00
210303	Цэвэр, бохир ус	2,503,200.00	2,503,724.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,294,400.00	19,294,400.00
210401	Бичиг хэрэг	2,627,800.00	2,627,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,768,900.00	9,768,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,206,300.00	2,206,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,300.00	42,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,649,100.00	4,649,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,161,700.00	7,161,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,161,700.00	7,161,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,054,200.00	6,054,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,330,700.00	3,330,700.00
210604	Урсгал засвар	2,723,500.00	2,723,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,733,000.00	3,733,000.00
210702	Дотоод албан томилолт	3,733,000.00	3,733,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	172,988,000.00	172,967,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,945,800.00	169,925,307.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,000.00	309,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	406,200.00	406,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,318,000.00	2,318,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,318,000.00	2,318,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,318,000.00	2,318,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	433,837,600.00	433,817,107.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	432,337,600.00	432,317,107.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	432,337,600.00	432,317,107.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,500,000.00	1,500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	1,500,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21	21
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	1	1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110,821,828.00	6948689.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	110,821,828.00	6948689.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,821,828.00	6948689.09
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,821,828.00	6948689.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,821,828.00	6,948,689.09
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	110,821,828.00	6948689.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,821,828.00	6948689.09
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,200,000.00	6,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,621,828.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	748,689.09

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Ж.Баттөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-өөс 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудитын хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/321 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлж, Мал эрүүлжүүлэх, малын халдварт болон халдваргүй өвчнөөс сэргийлэх дэвшилтэт арга технологийг боловсронгуй болгох, хүн амыг эрүүл хүнсээр хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малыг генетик нөөцийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 891989,4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17839,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1013498,7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 20270,0 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 733735,0 мянган төгрөг болж өмнөх

оноос 118041,1 мянган төгрөгөөр буюу 13,8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	308,061.0	117,020.0	(191,041.0)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	15,779.0	4,280.0	(11,499.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	292,282.0	112,740.0	(179,542.0)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	543,715.0	616,714.9	72,999.9
Үндсэн хөрөнгө	718,094.3	832,931.9	114,837.6
Хуримтлагдсан элэгдэл	(174,379.2)	(216,216.9)	(41,837.7)
Нийт хөрөнгө	851,776.0	733,735.0	(118,041.1)
Өр төлбөр	1,149.0	78.4	(1,070.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	850,627.0	733,656.6	(116,970.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	851,776.0	733,735.0	(118,041.1)

Бараа материалын дансны үлдэгдэл 112740.0 мянган төгрөг болж 179542.0 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийн шинж чанартай 107337,6 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэсэн, мөн 70853,7 мянган төгрөгийн үнэ бүхий ноос преслэгч тоног төхөөрөмжийг Жинст, Баянлиг, Шинэжинст, Баянцагаан, Гурванбулаг, Галуут, Баян-Овоо сумдын ЗДТГ болон Баянхонгор сумын “Хонгорын таван эрдэнэ” хоршоо, Баянхонгор сумын Адуун сүрэг хоршоо” гэсэн 2 аж ахуйн нэгжид шилжүүлсэн нь голлох нөлөөллийг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 832931.9 мянган төгрөг болж 114837.6 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын данснаас шилжиж ирсэн 107337,6 мянган төгрөг, төсвийн мөнгөөр худалдан авч орлого болгосон 7500.0 мянган төгрөгийн орлоготой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 733656.6 мянган төгрөг болж 116970.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 116970.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 896528,2 мянган төгрөг өмнөх оноос 451781.3 мянган төгрөгөөр буюу 101.6 хувиар өссөн байна.

Энэ нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого 455741,9 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 108065,9 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн үйл ажиллагааны орлого 532.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 103873.1 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт үйл ажиллагааны зардал 562907,8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 86940,0 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон НДШ 9357,3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9357.6 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 4758,6 мянга, албан томилолтын зардал 4420,8 мянга, урсгал шилжүүлгийн

зардал 29879,4 мянган төгрөгөөр тус тус буурч, хангамжийн зардал 29415.8 мянга, нормативт зардал 705.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 61246.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 56265.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 433837.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 433837.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 433837.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 433837.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 433837.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 433817.1 мянган төгрөгийг зарцуулж 20.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 433817.1 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байгаа бөгөөд 20.5 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн байна.

№	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>433,837,600.00</b>	<b>433,817,107.00</b>	<b>(20,493.00)</b>
	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>433,837,600.00</b>	<b>433,817,107.00</b>	<b>(20,493.00)</b>
	Бараа, үйлчилгээний зардал	292,153,700.00	292,153,700.00	-
70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	133,750,000.00	133,750,000.00	-
82517	Үлийн цагаан оготной тэмцэх	112,000,000.00	112,000,000.00	-
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	112,000,000.00	112,000,000.00	-
82542	Монгол мал хөтөлбөр	21,750,000.00	21,750,000.00	-
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	21,750,000.00	21,750,000.00	-
70805	<b>Хөдөө аж ахуй, газар тар бодлого</b>	<b>297,769,600.00</b>	<b>297,749,107.00</b>	<b>(20,493.00)</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	180,153,700.00	180,153,700.00	-
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,320,800.00	24,320,800.00	-
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,813,800.00	17,813,800.00	-
	Хангамж, бараа материалын зардал	19,294,400.00	19,294,400.00	-
210503	Нормативт зардал	7,161,700.00	7,161,700.00	-
	Эд хогшил худалдан авах	6,054,200.00	6,054,200.00	-
210702	Дотоод албан томилолт	3,733,000.00	3,733,000.00	-

	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	39,238,000.00	39,217,507.00	(20,493.00)
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,318,000.00	2,318,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	2,318,000.00	2,318,000.00	-

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ХХААЯ-аас худгийн хяналтын зардалд 748,7 мянган төгрөг, Баян-Овоо сумын ЗДТГ-аас худгийн оролцооны 1200,0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5000,0 мянган төгрөг, Баасанжаргалаас үрийн төмсний үнэ 50,0 мянга, нийт 6948,7 мянган төгрөгийн орлого оржээ.

Үүнээс 1 ажилтны орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээнд 5000,0 мянга, худгийн хяналтын зардлын шатахуунд 748,7 мянган төгрөг, Баян-Овоо сумын Удам судар ХХК-д мал ангилалтын зардалд 1200.0 мянга, төмсний үр худалдан авахад 50.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан, 3 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан 1 мэдээлэл хугацаа болоогүй байгаагаар Шилэн дансны мэдээлэлд харагдаж байгаа боловч дэлгэрэнгүй тулган шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээний зарлагын гүйлгээтэй холбоотой 12 мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: 2020 оны 4-р сард 7 сумын ЗДТГ-нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн оготно устгалтын санхүүжилтийн 5040.0-10080.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, мал ангилалтын зардалд 3 компанид шилжүүлсэн 5040.0-5250.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 2020 оны 5-р сард Бууцагаан сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд оготно устгалын 10080.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 2020 оны 12-р сард Нэхий ХХК-руу нормын хувцасны үнэ 7161.7 мянган төгрөгийн 1 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

үзүүлэлт	төрөл	удаа	хугацаандаа оруулсан	хоцорсон	хугацаа болоогүй
Бүтэн жилээр	9	9	5	3	1
хагас жилээр	4	4	4	0	0
Улирлаар	1	4	4	0	0
сар бүр	3	36	36	0	0
тухай бүр	8	96	95	1	0
ДҮН	25	149	144	4	1

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,4 сая төгрөгийн 2ш төлбөрийн акт тогтоосныг 2020.03.25-ны дотор барагдуулсан, 29884.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 205898.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан тухай 2020.05.06-ны өдрийн 1/127 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1467.2	2	1467.2			
Албан шаардлага	2	29884.0	0	29884.0			
Зөвлөмж	3	205898.7	3	205898.7			
Нийт дүн	7	237209.9	5	237209.9			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 57545.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 220.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 14647.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 43676.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд нь НДШ-д 593,5 мянга, ХХОАТ-т 859,5 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, өглөгийн үлдэгдлийг 78.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, **авлага**, 14.4.3.**бүх өр төлбөр**, заалтыг зөрчсөн, **“Оршин байх”** гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл 2827,0 мянган төгрөгийг 1453,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, өглөгийн үлдэгдлийг 78,4 мянган төгрөг болгон залруулга хийв.

2. Бараа материалын тусгай зориулалтын материалд 13116.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271-р тогтоолоор батлагдсан журмын 4.6-т “Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын “хүлээн зөвшөөрөлтийн зарчим” хангагдсан үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчиж, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тусгай зориулалтын материалын бүртгэлээс 13116.4 мянган төгрөгийн хөрөнгийг хасаж, үндсэн хөрөнгийн бүртгэлд шилжүүлэн залруулга хийв

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Өмнөх онд Төрийн аудитын газраас тогтоосон 220,8 мянган төгрөгийн төлбөрийн актыг холбогдох буруутай хүмүүсээр төлүүлээгүй төсвийн мөнгөнөөс шилжүүлж барагдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.”Төсвийн шууд

захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5.”батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд тогтоосон төлбөрийн акт 220.8 мянган төгрөгийг буруу этгээдээр төлүүлж төлбөрийг барагдуулах.

### Аудитын зөвлөмж

1. ХХААЯ-аас 2019 оноос эхлэн санхүүгийн бүртгэл хөтлөлтөд “Гүүк софт” ХХК-ны “Dynamic” программыг ашиглаж байгаагаас санхүүгийн тайланд 390,0 мянган төгрөгийн үнэтэй Санхүүгийн тооцоолох программ, 2003 оны 650,0 мянган төгрөгийн программ нь биет бус хөрөнгөд, бусад хөрөнгөд бүртгэлтэй 330,0 мянган төгрөг, нийт 1370.0 мянган төгрөгийн үнэтэй цалингийн программууд ашиглалтгүй болсон байна.

Энэ нь Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271-р тогтоолоор батлагдсан журмын 6.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн тооллогын дүн, өмч хамгаалах комиссын дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан материалын хамт хагас жилд нэг удаа ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “**Оршин байх**” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271-р тогтоолоор батлагдсан журмын 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж, ашиглалтгүй үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

2. 2020 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх тухай ХХААГ-ын даргын 2020.12.09-ны А/170 тушаал гарсан бөгөөд тооллогын комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярав нарыг оролцуулсан байна. Энэ нь эд хөрөнгийн тооллого явуулах журмын 1.3 “Тооллогын комисст Техникийн комисс, Өмч хамгаалах байнгын комиссыг оролцуулна”, 1.6 “эд хөрөнгийн тооллогыг тухайн эд хөрөнгийг гардан хариуцаж байгаа эд хариуцагч нарыг заавал байлцуулан явуулна” гэж заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогын комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярав нарыг оролцуулахгүй байх зөвлөмж өгөв.

3. Шилэн дансны тухай хуулийн 6.4 дэх заалтын дагуу мэдээллийг бүрэн байршуулсан эсэхийг тулган шалгахад 2020 оны 4-р сард 7 сумын ЗДТГ-нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 5040.0-10080.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, мал ангилалтын зардалд 3 компанид шилжүүлсэн 5040.0-5250.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 2020 оны 5-р сард Бууцагаан сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд оготно устгалын 10080.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 2020 оны 12-р сард Нэхий ХХК-руу нормын хувцасны үнэ 7161.7 мянган төгрөгийн 1 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн дагуу шилэн дансны мэдээллийн Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт хэсгийн цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг нөхөн байршуулж, цаашид цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмж өглөө.

4. Тус байгууллагын бараа материалын тусгай зориулалтын материалд үлдэгдлээр бүртгэлтэй байгаа 20,0 сая төгрөгийн “ямааны саалтуурын иж бүрдэл зогсоол бүхий тоног төхөөрөмж”, 12306,5 мянган төгрөгийн “Дуслын усалгааны систем”, 9.0 сая төгрөгийн

“Зөөврийн ноос преслэгч машин” зэрэг нийт 41306.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүд ашиглалтгүй хадгалагдаж байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх саналыг орон нутгийн өмчийн газар болон аймгийн ИТХ-д хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө.

5. Хөрөнгийн дахин үнэлгээний журналыг байдлын тайлангийн дахин үнэлгээтэй тулган шалгахад машин тоног төхөөрөмжийн 461575 төгрөг, тавилгын 865025 төгрөг нь байдлын тайлангийн дахин үнэлгээнд байхгүй байна. Энэ нь өмнөх онуудад ч мөн адил орхигдсон байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн дахин үнэлгээний журналын бичилтийг байдлын тайлангийн дахин үнэлгээтэй тохируулж, журналын бичилтийг 1326600 төгрөгөөр залруулах

Аудитаар илэрсэн 42676.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР



Б.ЦЭРЭНЧИМЭД  
Огноо: 2021.02.05

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.02.05


Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.02.05

**5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/175/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Тайлант онд нь НДШ-д 593,5 мянга, ХХОАТ-т 859,5 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, өглөгийн үлдэгдлийг 78.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан	1531,4	Санхүүгийн тайланд залруулах	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
2	Бараа материалын тусгай зориулалтын материалд 13116.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэлтэй байна	13116,4	Санхүүгийн тайланд залруулах	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
3	Өмнөх онд Төрийн аудитын газраас тогтоосон 220,8 мянган төгрөгийн төлбөрийн актыг холбогдох буруутай хүмүүсээр төлүүлээгүй төсвийн мөнгөнөөс шилжүүлж барагдуулсан байна.	220,8	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
4	ХХААЯ-аас 2019 оноос эхлэн санхүүгийн бүртгэл хөтлөлтөд "Гүүк софт" ХХК-ны "Dynamec" программыг ашиглаж байгаагаас санхүүгийн тайланд 390,0 мянган төгрөгийн үнэтэй Санхүүгийн тооцоолох программ, 2003 оны 650,0 мянган төгрөгийн программ нь биет бус хөрөнгөд, бусад хөрөнгөд бүртгэлтэй 330,0 мянган төгрөг, нийт 1370.0 мянган төгрөгийн үнэтэй цалингийн программууд ашиглалтгүй болсон байна.	1370,0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
5	2020 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх тухай ХХААГ-ын даргын 2020.12.09-ны А/170 тушаал гарсан бөгөөд тооллогын комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярав нарыг оролцуулсан байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
6	Шилэн дансны тухай хуулийн 6.4 дэх заалтын дагуу мэдээллийг бүрэн байршуулсан эсэхийг тулган шалгахад 2020 оны 4-р сард 7 сумын ЗДТГ-нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 5040.0-10080.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, мал ангилалтын зардалд 3 компанид шилжүүлсэн 5040.0-5250.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 2020 оны 5-р сард Бууцагаан сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд оготно устгалын 10080.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 2020 оны 12-р сард Нэхий ХХК-руу нормын хувцасны үнэ 7161.7 мянган төгрөгийн 1 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
7	Тус байгууллагын бараа материалын тусгай зориулалтын материалд үлдэгдлээр бүртгэлтэй байгаа 20,0 сая төгрөгийн "ямааны саалтуурын иж бүрдэл зогсоол бүхий тоног төхөөрөмж", 12306,5 мянган төгрөгийн "Дуслын усалгааны систем", 9.0 сая төгрөгийн "Зөөврийн ноос преслэгч машин" зэрэг нийт 41306.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүд ашиглалтгүй хадгалагдаж байна.	41306,5	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил



Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	Хөрөнгийн дахин үнэлгээний журналыг байдлын тайлангийн дахин үнэлгээтэй тулган шалгахад машин тоног төхөөрөмжийн 461575 төгрөг, тавилгын 865025 төгрөг нь байдлын тайлангийн дахин үнэлгээнд байхгүй байна. Энэ нь өмнөх онуудад ч мөн адил орхигдсон байна.	1326.6	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Баттөр, Б.Мөнх-Оргил
<b>ДҮН</b>		<b>57545,1</b>			

